

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ-НИЙГМИЙН БАЙДЛЫН 2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

2014.10.07

Алтай хот

Төл бойжилт: Аймгийн дүнгээр 838.3 мянган толгой буюу төллөх насны хээлтэгчийн 91.5 хувь төллөж, 814.9 мянган төл 97.2 хувиар бойжиж байна. Төллөх ингэний 49.2, гүүний 76.9, үнээний 80.8, эм хонины 93.8, эм ямааны 91.8 хувь тус тус төллөж, 100 эхээс ботго 48, унага 75, тугал 79, хурга 92, ишиг 89-ийг бойжууллаа. Гарсан төлөө Хөхморьт сум 100 хувь бойжуулж, Алтай, Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Чандмань, Баян-Уул, Бигэр, Жаргалан, Цогт, Эрдэнэ, Есөнбулаг сумд 92.5-99.3 хувиар тус тус бойжуулж, харин Цээл сумд төлийн хорогдол 22.3 хувийг эзэлж байна.

Мал онд оролт: Аймгийн мал сүрэг 99.1 хувиар онд орж, бүгд 27.1 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх мөн үеэс 15.0 хувиар бага байна. Бигэр, Тайшир, Халиун, Цээл, Эрдэнэ сумд 1.4-6.1 хувиар малаа хорогдуулсан нь нийт хорогдлын 73.3 хувийг эзэлж байгаа ба бусад сумууд малаа 96.4-98.9 хувиар онд оруулжээ.

Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэл: Үр тариа 113.4 тн, төмс 407.4 тн, хүнсний ногоо 222.3 тн, тэжээлийн ургамал 791.2 тн-ыг тус тус хурааж, байгалийн хадлан 4499.6 тн, гар тэжээл 141.5 тн-ыг бэлтгээд байна.

Хилийн худалдаа: 4 удаа хилийн худалдаа хийгдэж 83.8 сая ам долларын төмрийн хүдрийн баяжмал гаргаж, цемент, цагаан будаа болон бусад тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл зэрэг 5.3 сая ам долларын бараа материал оруулж ирэв.

Үнэ: Малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд сонгогдсон Алтай хотод сарын эцэст доорх ханштай байлаа.

Сарууд	I	II	III	VI	V	VI	VII	VIII	IX
1 кг ноолуурын үнэ /мянган төгрөг/	60.0	63.0	50.0	70.0	68.0	66.0	67.0	67.5	65.0

Аж үйлдвэр: Тайлант хугацаанд Алтай-Улиастай Эрчим хүчний систем, Мандал голомт, Тулга-Алтай, Ентүм, Ундрам-оюу, Шимт дээж, Ундарга-Алтай, Баярт олон, Залуур-Алтай, Даянтайшир, Ариун-Өргөө, Айргийн хад, Дуурсах-Алтай зэрэг 57 аж ахуйн нэгж, 111 хувиараа үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаа явууллаа.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр 6 тэрбум 998 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 тэрбум 432.4 сая төгрөг буюу 25.8 хувиар буурчээ. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 136.7 сая төгрөг буюу 33.6 хувиар өсч, харин боловсруулах аж үйлдвэрийнх 23.6 сая төгрөг буюу 1.9 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 2 тэрбум 545.5 сая төгрөг буюу 32.7 хувиар буурлаа.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеийнхээс дулааны эрчим хүч үйлдвэрлэл, сувагжуулалт, түгээсэн ус, нүүрс, талх нарийн боов үйлдвэрлэл, архи дарс 1.5-62.7 хувиар өсч блок, хуванцар цонх үйлдвэрлэл, улаан тоосго, амтат ус, ундаа, арвайн гурил үйлдвэрлэл нь 1.4-5.8 дахин өсч, харин гутал ботинк, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, хиаман төрлийн бүтээгдэхүүн, хувцас үйлвэрлэл, 16.4-36.2 хувиар буусан байна.

Аж үйлвэрийн бүтээгдэхүүн үйлвэрлэлийн 87.9 хувийг Есөнбулаг, 2.3 хувийг Тайшир, 2.0 хувийг Дарив, 1.4 хувийг Чандмань, 0.9 хувийг Эрдэнэ, 0.8 хувийг Дэлгэр, 0.7 хувийг Бигэр, Цээл, Цогт 0.6 хувийг Алтай сумдад эзэлж байгаа нь эдгээр сумдад үйлдвэрлэл илүү хөгжиж байгааг харуулж байгаа ба үлдсэн 2.0 хувийг бусад сумд эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 6 тэрбум 499.8 сая төгрөг болж, нийт бүтээгдэхүүн үйлвэрлэлийн 93.0 хувийг борлуулжээ.

Барилга: Барилга угсралт, их засвар арван нэгэн тэрбум 721.1 сая төгрөгийн ажил хийж, үүнээс арван тэрбум 451.0 сая төгрөгийн шинэ барилга, нэг тэрбум 270.1 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт зургаан тэрбум 2.4 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 102.8 хувиар биелүүлж, аймгийн төсвийн нийт найман тэрбум 639.8 сая төгрөг орлого болж төлөвлөгөөг 102.5 хувиар давуулан биелсэн байна.

Үүнээс татварын орлого 118.8 хувиар биелсэн байна. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Дэлгэр Цогт, Цээл, Есөнбулаг сумд 0.4-1.3 хувиар давуулж, улсын төсвийн орлогын төлөвлөгөөг Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Жаргалан, Тайшир, Халиун, Хөхморьт, Чандмань, Шарга, Төгрөг сумд 4.1-16.8 хувиар тасласан байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтий 77.0 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 95.8, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 94.5, бараа үйлчилгээ бусад зардлын 107.1 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Банкны мөнгөн орлого, зарлага: Бүгд 19 тэрбум 205.2 сая төгрөгийн зузаатгал хийж кассын гүйлгээнээс 215 тэрбум 211.1 сая төгрөг татаж, монгол банкинд 19 тэрбум 191.7 сая төгрөг шилжүүлж, гүйлгээнд 222 тэрбум 437.7 сая төгрөг гаргалаа. Зээлийн өрийн бүх үлдэгдэл 81 тэрбум 768.5 сая төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 0.3 хувийг эзэлж байна. Иргэдийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 4.0 хувиар буурчээ.

Хүн ам: Эхний хагас жилийн байдлаар 983 эх амаржиж, 986 хүүхэд мэнд төрлөө. Одоогоор аймгийн хэмжээнд эмнэлгийн хяналтад авагдсан 610 жирэмсэн эх байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 27 тохиолдол бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 403 халдварт өвчний өвчлөл дотроос гепатит 2.2, бэлгийн замын халдварт өвчнүүд 50.3, сүрьеэ 6.7 хувийг тус тус эзэлж байна. Хорт хавдраар өвчилсөн 96 тохиолдол шинээр бүртгэгдсэн ба энэ өвчнөөр нас барсан 64, осол гэмтлээр нас барсан 27 тохиолдол бүртгэгдлээ. Тайлант онд эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд давхардсан тоогоор 180.7 мянган хүнд үзлэг хийж, 11.4 мянган хүнийг хэвтүүлэн эмчилж, 87.6 мянган ор хоног ашиглажээ.

Аудитын газар: Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг 215 байгууллагын 291 санхүүгийн тайланд аудит хийлээ. Санхүүгийн тайланд аудит хийсэн дүнгээс үзэхэд 208 санхүүгийн тайланд зөрчилгүй, 76 санхүүгийн тайланд хязгаарлалттай, 7 санхүүгийн тайланд сөрөг дүгнэлт өглөө. Өмнөх оноос аудитын тоо 87-оор өссөн бол зөрчилгүй дүгнэлтийн тоо 126-аар, хязгаарлалттай дүгнэлтийн тоо 39-өөр өсч, сөрөг дүгнэлтийн тоо 3-аар тус тус буурсан байна.

Аудитаар 106 тэрбум 737.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсний 4.0 хувийг буюу 4.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 100 тэрбум 70.6 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулах 464 заалт бүхий албан шаардлага, 55 заалт бүхий зөвлөмж өгч, 1429.2 сая төгрөгийг төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоолоо. Аудитаар илэрсэн зөрчлөөс хамааран 30 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд саналаа хүргүүлжээ.

Мэргэжлийн хяналтын газар: Энэ улирлын байдлаар 288 хуулийн этгээд, 4496 иргэнийг хамарсан мэргэжлийн хяналт хийж, 1647 зөрчил илрүүлсний 64.9 хувийг газар дээр нь арилгуулав. Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн зөрчилтэй үйл ажиллагааг засахад чиглэгдсэн 11 сая 614.0 мянган төгрөгийн торгууль тавьж барагдуулалт 71.1 хувьтай байна. Мөн гаргасан дүгнэлтийн 35, албан шаардлагын 71.7 хувийг биелүүлээд байна. Гуравдугаар улирлын байдлаар 2 байгууллагын үйл ажиллагааг бүрэн зогсоож, 6 байгууллагын үйл ажиллагааг түр зогсоожээ. Бүгд 35 байгууллагын санхүүгийн баримтанд шалгалт хийж 49.9 сая төгрөгийн акт тавьсны 38.0 хувийг барагдуулаад байна.

Хөдөлмөрийн хэлтэс: Энэ улирлын байдлаар хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйчүүд 1200 болсны дотор 57.8 хувь буюу 693 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 379 нь дээд, 155 нь тусгай дунд, 43 нь мэргэжлийн анхан шатны, 441 нь бүрэн дунд, 114 нь бүрэн бус дунд, 47 нь бага, 21 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна. Тус алба тайлант хугацаанд 110 хүнийг түр болон бүр ажилд ороход нь зуучлав.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс: 9.6 мянган хүнд 3224.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгожээ.

Соёл спорт аялал жуулалын газар: Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 11 төрлөөр 128 тамирчин оролцсоноос шатар, таеквондо, спорт авиралт, кросс гүйлтээр тус тус 5 алтан медаль, жү-до бөх, таеквондо, спорт авиралт, кросс гүйлт, монголын хамгийн хурдан гүйгч, олон төрөлтөөр 7 мөнгө, хүрэл медаль 10 тус тус авсан байна.

Баруун бүсийн тэмцээнд 4 төрлөөр 136 тамирчин оролцож жү-до бөхөөр алт, мөнгөн медаль тус бүр 6, хүрэл медаль 4, волейболоор мөнгөн медаль 15, таеквондоогоор мөнгөн медаль 4, хүрэл медаль 10 тус тус авсан байна.

Ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 төрлөөр 15 тамирчин оролцож Жү-до бөхөөр алт, мөнгө, хүрэл, уулын авиралтаар алт, хүрэл медаль авсан байна.

Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 төрлөөр 18 тамирчин оролцож таеквондоогоор 1 алт, шатраар 1 алт, спорт авиралтаар 1 хүрэл, пара хөнгөн атлетик 3 алт, 4 мөнгө, 3 хүрэл медаль тус тус авсан байна.

Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд уулын авиралтаар 6 алт, 6 мөнгөн медаль авсан байна.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс: Тус төв “Чанарын баталгаажуулалтанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д орсон бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ явуулж стандартын шаардлага хангасан 8 сумын 28 хүнсний дэлгүүр, 3 зоогийн газар, баар, 1 зочид буудал, 1 гоо сайхан, 2 шатахуун түгээх станцад “Тохирлын гэрчилгээ” олгожээ. “Алтайн хүдэр” ХХК-ний экспортлож байгаа 320.0 мянган тонн төмрийн хүдрийн баяжмалд гаалийн төв лабораторийн дүнг үндэслэн баталгаажуулалт хийж, Тохирлын гэрчилгээ олгосон.

Хэмжүүрийн лаборатори механик хэмжүүр, цахилгаан хэмжил, эзлэхүүн багтаамжийн төрлөөр нийт 132 аж ахуйн нэгж иргэний 537 ширхэг хэмжүүр хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалтанд хамруулсан байна.

СХЗГ-н стандарт, мэдээлэл лавлагааны төвөөс шинээр батлагдсан болон шинэчлэгдсэн стандартыг цахим хэлбэрээр захиалан авч 84 аж ахуйн нэгж, иргэнд 207 стандартаар үйлчилжээ.

Байгаль орчны газар: Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчиндоо хандах хандлагыг төлөвшүүлэх, байгаль хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2014 оны 09 сарын 10-16 өдрүүдэд Цогт сумын Баянтоорой тосгон, Цээл, Бугат сумдад сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж 600 гаруй хүүхэд багачууд, иргэд хамрагдлаа. Аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар хамтран аж ахуй нэгж байгууллагын тохижилтыг сайжруулах зорилгоор “Сайн уу муу юу аль нь вэ” цуврал нэвтрүүлгийг 7 хоног бүр явуулж эхэлж байгаа бөгөөд “Миний нутаг” телевизтэй хамтран зураг авалтыг хийж байна. Сүүлийн жилүүдэд хууль бус ангийн хэрэг нэмэгдэх хандлагатай байгаа учир Амьтны тухай хууль, БОНХ-ийн сайдын 2014 оны А-61 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор хууль бус агнуур, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2014 оны 8 сарын 19-ний өдөр А/388 дугаар захирамж гарч, тус газрын албан хаагчид тарваганы хяналт шалгалтыг хуваарийн дагуу ажиллаж байна.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар: Аймгийн Засаг даргын газар эзэмшүүлэх захирамжуудаар гарсан 21 иргэнд орон сууцны зориулалтаар, үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар 9 иргэнд, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2 иргэнд, Махны үйлдвэрийн зориулалтаар 1 аж ахуйн нэгж байгууллагад, Албан конторын зориулалтаар 2 аж ахуйн нэгж байгууллагад, Орон сууц, шугам сүлжээ, дулааны цахилгаан станцын зориулалтаар 6 төрийн байгууллагад, хүлэмжийн зориулалтаар 8 иргэн, гахайны аж ахуйн зориулалтаар 2 иргэн нийт 51 нэгж талбар газарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулиуд: Ерөнхий боловсролын 28 сургууль, 28 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Эдгээр сургуулиудад 11.6 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.3 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1197 хүүхэд элсэн суралцаж байна.

АШУИҮИС-ийн салбар: Нийт ажиллагсад 86, үүнээс багш 60, долоон мэргэжлээр 203 оюутан элсэн сурч байна. Үүнээс их эмч 45, уламжлалт эмчилгээний сувилагч 11, бакалавр сувилагч 40, эм найруулагч 24, эх барих бага эмч 15, эх баригч 29, сувилагч 39 мэргэжлээр тус тус төгссөн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Энэ хичээлийн жилд 758 суралцагчид сурч, нийт 74 ажиллагсад, мэргэжлийн 35, ерөнхий боловсролын 14 багштай ажиллаж байна. 2013-2014 оны хичээлийн жилд 11 мэргэжлээр 291 хүүхэд төгссөн байна.

Тэгш-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 106 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Батлан Хамгаалахад туслах Нийгэмлэг: Авто машины жолоочийн дамжаагаар 14 хүнийг “В” ангиллаар жолооч, “С” ангиллаар 8 хүнд жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Ихэс-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 56 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Авто тээвэр: Зорчигч, ачаа тээврээр байгууллага иргэдэд үйлчилж 805.1 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Нефть хангамжийн бааз: 2 тэрбум 779.7 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалыг татан авч 5 тэрбум 760.8 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалын борлуулалт хийлээ.

Цахилгаан холбоо компани: Суурин телефон цэгийн тоо 823, холбоо ашиглалтын орлого 172.2 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 107.9 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний 2 цэг 20-н суудалтай ажиллаж интернетээр дунджаар 8.2 мянган хүнд үйлчилжээ.

Шуудан үйлчилгээний газар: Сум, хот, хооронд шуудан, хэвлэл захиалга, илгээмж, зорчигч тээврээр үйлчилэн бүгд 57.3 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Мобиком корпорацийн Говь-Алтай дахь салбар: Тус салбар үндсэн хэрэглэгч 0.9 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 21.9 мянга, бүгд 22.8 мянган хэрэглэгчид үүрэн телефоноор үйлчилгээ үзүүлж байна.

Юнител ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь үндсэн хэрэглэгч 0.8 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 16.1 мянга, бүгд 16.3 мянган хэрэглэгчтэй байна.

Ж-Мобайл ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь дараа төлбөрт 0.9 мянга, урьдчилсан төлбөрт 22.3 мянган хэрэглэгчтэй болоод байна.

Зэрэглээт-Алтай телевиз: Тус телевиз нь 0.4 мянган хэрэглэгчтэй 9.1 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Миний нутаг телевиз: Мэдээ, сонины тоймыг 92 цаг, хүүхэлдэйн болон уран сайхны киног 420 цаг, зар сурталчилгааг 45 цаг, захиалгат болон шууд нэвтрүүлгийг 15 цаг, шууд болон захиалгат нэвтрүүлгийг 98 цаг цацан гаргасан байна.

Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс: Хурдан морь уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих талаар хурдан морь уралдаанч хүүхдүүд, эцэг эхчүүдэд телевиз радиогоор мэдээлэл өгч баяр наадмын хурдан морины уралдааны комисстой хамтран ажиллалаа. Уралдаанд нийт 536 мориог 161 хүүхэд унаж уралдууллаа. Уралдааны үед 5 хүүхэд мориноос унаснаас 4 хүүхэд гэмтэлгүй, 1 хүүхэд хөнгөн гэмтэл авсныг тухайн үед нь үзүүлж, эмчийн үзлэгт хамрууллаа.

Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх хөгжүүлэх зорилгоор гадаадын сайн дурын ажилтнууд болон 7-8-р ангийн сурагчидтай хамтран зохион байгуулдаг “Жаргалын төв” хөтөлбөрийн 2014-2015 оны хичээлийн шинэ жилийн сургалтын нээлтийг зохион байгуулж, 23 хүүхэд хамрагдан суралцаж байна.

Ардын дуу Бүжгийн “Алтай” чуулга: Нийт 13 удаагийн тоглолт хийж, 7.9 мянган үзэгчид үзэж нийт 5.8 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Аймгийн музей: Онцгой болон түүх дурсгал, эд өлгийн 2.5 мянган үзмэрээр 1.6 мянган үзэгчдэд үйлчилж 1.4 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Аймгийн нийтийн номын сан: Шинээр 612 уншигч бүртгэж, 6.1 мянган уншигчид 4.9 мянган номоор үйлчилж, уншигчдын эрэлт хэрэгцээг ханган шинэ мэдээ мэдээллээр түргэн шуурхай үйлчлэх зорилгоор 310 аман болон бичгийн лавлагаа өгч, 489 ширхэг ном сэлбэн зассан байна.

Онцгой байдлын хэлтэс: Галын дуудлаганд 25 удаа гарч, 12.6 мянган айл өрх, 443 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж зөвлөгөө өгч, 126.6 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварчээ. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалж гал түймрийн улмаас 46.1 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Энэ улирлын байдлаар 25 удаагийн гал түймэр гарсны 15-ийг нь тус хэлтэс, үлдсэн 10 түймрийг иргэд өөрсдөө унтраасан байна.

Гамшгийн мэдээ: Онцгой байдлын эрэн хайх, аврах бүлэг 11 удаа техникийн болон ослын

холбогдолтой дуудлага хүлээн авч **ажилласан** байна.

Гэмт хэрэг: Байгууллага, иргэдийн 224.5 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 149 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс хулгай гэмт хэрэг, үүнээс орон байрны хулгай, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргүүд дийлэнх хувийг эзэлж байна. Гарсан нийт хэргийн 55.7 хувь нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.

Баривчлагдсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 28 хүн буюу 15.1 хувиар, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо өмнөх онтой харьцуулахад 45 хүн буюу 21.0 хувиар өссөн байна.

Аймгийн шүүх: Жилийн эхнээс 380 иргэний нэхэмжлэл хүлээн авсан байна. Үүнээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийг үндэслэн 58 иргэний нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 57 иргэний хэрэг, түдгэлзүүлсэн 8 иргэний хэрэг нийт 65 иргэний хэргийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оны мөн үед 451 иргэний хэрэг хянан шийдвэрлэж, хялбаршуулсан журмаар 82 шийдвэрлэж байсан бол энэ онд 253 иргэний хэрэг хянан шийдвэрлэж 47 хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн байна.

	Төллөсөн хээлтэгч						Хорогдсон төл					
	Бүгд	ингэ	гүү	үнээ	эм хонь	эм ямаа	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг
1.Алтай	25259	350	363	335	4214	19997	828	45	33	31	170	549
2.Баян-Уул	58264	211	1208	1006	22473	33366	510	7	17	9	126	351
3.Бигэр	37815	239	692	1019	9516	26349	2827	10	31	25	659	2102
4.Бугат	32736	129	433	275	10326	21573	681	2	19	12	159	489
5.Дарив	54389	244	1031	796	20665	31653	999	18	51	29	195	706
6.Дэлгэр	73919	270	1120	882	27716	43931	566	2	20	9	160	375
7.Жаргалан	35416	107	325	469	12884	21631	469	3	4	9	205	248
8.Тайшир	30107	71	534	423	11091	17988	765	10	24	14	179	538
9.Тонхил	61068	33	1539	761	30495	28240	426	3	72	43	127	181
10.Төгрөг	41146	738	779	432	14799	24398	1109				282	827
11.Халиун	61156	511	977	1160	18139	40369	1758	12	17	11	369	1349
12.Хөхморьт	32896	259	1460	890	11354	18933	0					
13.Цогт	67979	325	570	1000	17937	48147	1996	2	5	6	378	1605
14.Цээл	47074	142	726	712	10696	34798	5199	13	80	84	1172	3850
15.Чандмань	45887	145	761	493	16443	28045	960	3	3	4	234	716
16.Шарга	38755	722	653	940	8130	28310	575	5	10	15	45	500
17.Эрдэнэ	48830	235	390	148	8914	39143	2805	16	14	8	735	2032
18.Есөнбулаг	45563	126	865	845	14895	28832	874	1	12	25	347	489
ДҮН	838259	4857	14426	12586	270687	535703	23347	152	412	334	5542	16907
7/31/2013	713232	4339	11649	9287	229395	458562	15087	176	372	274	3967	10298

	Бойжсон төл						Бойжилтын хувь					
	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг
1.Алтай	24431	305	330	304	4044	19448	96.7	87.1		90.7	96.0	97.3
2.Баян-Уул	57754	204	1191	997	22347	33015	99.1	96.7	98.6	99.1	99.4	98.9
3.Бигэр	34988	229	661	994	8857	24247	92.5	95.8	95.5	97.5	93.1	92.0
4.Бугат	32055	127	414	263	10167	21084	97.9	98.4	95.6	95.6	98.5	97.7
5.Дарив	53548	226	980	767	20541	31034	98.2	92.6	95.1	96.4	99.1	97.8
6.Дэлгэр	73353	268	1100	873	27556	43556	99.2	99.3	98.2	99.0	99.4	99.1
7.Жаргалан	35099	104	321	460	12776	21438	98.7	97.2		98.1	98.4	98.9
8.Тайшир	29860	61	510	409	11048	17832	97.5	85.9	95.5	96.7	98.4	97.1
9.Тонхил	60649	30	1467	718	30373	28061	99.3	90.9	95.3	94.3	99.6	99.4
10.Төгрөг	40037	738	779	432	14517	23571	97.3	100.0	100.0	100.0	98.1	96.6
11.Халиун	59398	499	960	1149	17770	39020	97.1	97.7	98.3	99.1	98.0	96.7
12.Хөхморьт	32896	259	1460	890	11354	18933	100.0	100.0		100.0	100.0	100.0
13.Цогт	65983	323	565	994	17559	46542	97.1	99.4	99.1	99.4	97.9	96.7
14.Цээл	41875	129	646	628	9524	30948	89.0	90.8	89.0	88.2	89.0	88.9
15.Чандмань	44927	142	758	489	16209	27329	97.9	97.9	99.6	99.2	98.6	97.4
16.Шарга	38180	717	643	925	8085	27810	98.5	99.3		98.4	99.4	98.2
17.Эрдэнэ	46025	219	376	140	8179	37111	94.3	93.2	96.4	94.6	91.8	94.8
18.Есөнбулаг	44689	125	853	820	14548	28343	98.1	99.2	98.6	97.0	97.7	98.3
ДҮН	814912	4705	14014	12252	265145	518796	97.2	96.9	97.1	97.3	98.0	96.8
7/31/2013	699020	4163	11277	9014	225695	448871	97.9	95.9	96.8	97.0	98.3	97.8

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДЛЫН МЭДЭЭ

	эзлэх хувь	Бүгд хорогдол						Бүгдээс өвчнөөр хорогдсон						Бүгдээс хорогдсон хээлтэгч					
		Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Бүгд	ингэ	гүү	үнээ	эм хонь	эм ямаа
1.Алтай	1.39	889	71	61	65	271	421	0					402	28	26	23	123	202	
2.Баян-Уул	0.31	497	1	16	12	125	343	39			2	15	22	28			1	12	15
3.Бигэр	1.35	1566	3	46	26	458	1033	204	2	9	8	51	134	354	1	11	8	97	237
4.Бугат	0.50	403	1	19	8	100	275	0					42		2		21	19	
5.Дарив	0.31	410	3	28	17	113	249	0					45			4	11	30	
6.Дэлгэр	0.25	462	2	0	14	125	321	28	2	0	6	4	16	49			5	12	32
7.Жаргалан	0.85	840	1	0	4	369	466	4	1		3		275	1		1	118	155	
8.Тайшир	3.39	2464	5	7	4	48	2400	111		1	2	6	102	521	3	3	0	11	504
9.Тонхил	0.65	949	1	56	36	317	539	0					0	26		1		10	15
10.Төгрөг	0.27	281				171	110	7					7	64				32	32
11.Халиун	1.63	2520	20	39	25	494	1942	120	6	2	2	46	64	1015	3	5	6	153	848
12.Хөхморьт	0.00	0						0					0						
13.Цогт	0.21	406	0	5	3	74	324	32				18	14	180		1	2	32	145
14.Цээл	6.09	7656	7	35	32	1652	5930	76	0	0	0	27	49	2010	1	3	1	402	1603
15.Чандмань	0.80	995	1		2	303	689	0	0				242			1	69	172	
16.Шарга	0.34	361	6	17	11	26	301	14					14	28	2	3	3	7	13
17.Эрдэнэ	3.70	5650	15	59	5	1171	4400	0					547	2	5	1	80	459	
18.Есөнбулаг	0.75	869	1	13	14	345	496	89	1	2	4	35	47	241		1	2	96	142
ДҮН	1.22	27218	138	401	278	6162	20239	724	12	14	27	202	469	6069	41	61	58	1286	4623
9/30/2013	1.67	31872	162	516	265	8312	22617	1810	35	44	49	642	1040	5348	50	87	63	1649	3499

УРГАЦ ХУРААТ, ХАДЛАН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН МЭДЭЭ /тонноор/

2014.10.07

Д/д	Сумын нэр	Үр тариа		Төмс		Хүнсний ногоо			Тэжээлийн ургамал		Бэлтгэсэн өвс	Бэлтгэсэн гар тэжээл	Хужил шүү
		Хураасан ургац	Усалгаатай талбайгаас	Хураасан ургац	Усалгаатай талбайгаас	Хураасан ургац	Усалгаатай талбайгаас	Хүлэмжээс	Хураасан ургац	Усалгаатай талбайгаас			
1	Есөнбулаг	14.5	14.5	136.4	136.4	88.0	57.0	31.0	71.4	71.4	392	32	245
2	Алтай	0.0	0.0	1.5	1.5	1.9	1.9	0.0	0.0	0.0	67.75	1.9	0
3	Баян-Уул	0.0	0.0	2.8	2.8	1.8	0.8	1.0	0.0	0.0	30	10	215
4	Бигэр	2.0	2.0	1.0	1.0	1.2	1.2	0.0	260.0	260.0	340	5	0
5	Бугат	3.5	3.5	13.4	13.4	5.8	5.8	0.0	310.0	310.0	360	2.5	0
6	Дарив	2.0	2.0	1.5	1.5	0.9	0.8	0.1	0.0	0.0	99.1	2	35
7	Дэлгэр	1.3	1.3	10.8	10.8	17.4	13.9	3.5	5.5	5.5	195.2	28.9	0
8	Жаргалан	2.3	2.3	6.1	6.1	4.0	2.4	1.6	19.3	19.3	260	0.25	8
9	Тайшир	17.4	17.4	6.0	6.0	2.4	1.9	0.5	0.0	0.0	140	2.12	0
10	Тонхил	0.0	0.0	10.0	10.0	4.8	1.5	3.3	0.0	0.0	205.3	7.5	0
11	Төгрөг	4.0	4.0	18.0	18.0	12.4	12.4	0.0	6.5	6.5	14	1.8	0
12	Халиун	4.2	4.2	25.9	25.9	17.6	17.4	0.3	5.0	5.0	574	2	0
13	Хөхморьт	0.0	0.0	1.0	1.0	2.0	1.4	0.6	0.0	0.0	145.2	15	0
14	Цогт	0.0	0.0	25.0	25.0	4.0	4.0	0.0	0.0	0.0	5	1.5	0
15	Цээл	0.0	0.0	5.0	5.0	0.0	0.0	0.0	2.0	2.0	75	15	30
16	Чандмань	60.0	60.0	45.0	45.0	11.0	11.0	0.0	105.5	105.5	0	10	0
17	Шарга	2.2	2.2	97.5	97.5	47.0	47.0	0.0	6.0	6.0	1500	0	0
18	Эрдэнэ	0.0	0.0	0.5	0.5	0.2	0.0	0.2	0.0	0.0	97	4	2
ДҮН		113.4	113.4	407.4	407.4	222.325	180.35	41.971	791.2	791.2	4499.6	141.5	535.0
ӨМҮ		207.4	207.4	164.3	164.3	89.8	89.8		438.0	438.0	3000.3	105.7	

ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ/мянган төгрөг/

А	Б	В	Алтай	Баян-Уул	Бигэр	Бугат	Дарив	Дэлгэр	Жаргалан	Тайшир	Тонхил	Төгрөг	Халиун	Хөхморьт	Цогт	Цээл	Чандмана	Шарга	Эрдэнэ	Есөнбулаг	
1.1 Тэмээ		IX	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	
Буур	1	тол	1300	1100	1400	1400	1100	1500	1100	1300	1100	1100	1300	1300	1300	1400	1000	1200	1000	1100	
Нас гүйцсэн	Нас гүйцсэн ат	2	тол	1100	1100	1200	1000	1000	1300	1200	1200	1000	1000	1300	1100	1400	1400	1000	1000	1000	1100
	Нас гүйцсэн ингэ	3	тол	650	800	1000	900	800	900	1100	1000	800	900	1000	1000	950	1200	950	900	900	700
Өсвөр	Эр шилбэ	4	тол	600	700	600	500	700	600	600	800	500	650	800	800	700	900	850	500	600	550
	Эм шилбэ	5	тол	600	700	600	500	600	600	800	500	650	800	800	800	700	850	800	500	600	500
Төл	Эр ботго	6	тол	300	350	300	200	350	200	250	400	250	400	400	400	300	350	400	200	200	220
	Эм ботго	7	тол	300	350	300	200	350	200	250	400	250	400	400	400	300	350	400	200	200	220
1.2 Адуу																					
Азарга	8	тол	1000	800	1200	1100	1200	1000	1000	1300	800	900	1100	1000	800	1500	1000	800	900	1000	
Нас гүйцсэн	Соёолон үрээ	9	тол	800	700	1000	750	800	800	800	800	800	1100	900	700	1400	700	600	800	800	
	Соёолон гүү	10	тол	650	600	800	650	700	600	700	700	700	650	900	800	700	1100	600	500	600	600
Өсвөр	Шүдлэн үрээ	11	тол	450	500	600	500	600	500	600	600	500	800	700	500	800	550	300	600	550	
	Шүдлэн байдас	12	тол	350	500	600	500	600	500	600	600	550	500	700	700	450	700	550	300	550	550
Төл	Эр унага	13	тол	180	200	300	150	200	200	200	250	250	300	350	250	250	400	300	200	200	150
	Эм унага	14	тол	150	200	300	150	200	200	200	250	250	300	350	250	250	400	300	200	200	150
1.3 Үхэр																					
Бух	15	тол	1000	1000	1300	1200	1000	1100	900	900	900	1000	1300	1100	1200	1400	1000	1000	1000	1000	
Нас гүйцсэн	Хязаалан шар	16	тол	800	1000	1200	1100	1000	1100	1200	1000	900	1000	1300	1000	1100	1300	900	1000	1000	1100
	Хязаалан дөнж	17	тол	700	800	1000	800	900	900	1100	850	800	800	1000	900	850	1000	800	750	800	900
Өсвөр	Шүдлэн эр үхэр	18	тол	600	700	700	700	800	650	1000	600	600	550	850	900	700	800	700	600	700	800
	Шүдлэн гунж	19	тол	550	700	700	600	700	650	950	600	600	550	800	800	700	700	600	600	600	800
Төл	Эр тугал	20	тол	250	250	250	200	300	200	250	300	150	300	400	300	250	350	300	200	200	120
	Эм тугал	21	тол	250	250	250	200	300	200	250	300	150	300	400	300	250	350	300	200	200	120
1.4 Хонь																					
Хуц	22	тол	200	200	220	200	180	180	200	200	150	200	200	200	180	200	220	200	160	200	
Нас гүйцсэн	Эр хонь	23	тол	200	180	200	150	180	180	200	170	200	200	160	180	200	200	200	150	200	
	Эм хонь	24	тол	160	150	130	130	150	130	150	110	150	150	110	150	150	150	140	130	160	
Өсвөр	Эр төлөг	25	тол	120	120	90	100	140	100	150	100	80	140	100	100	100	120	100	110	130	
	Эм төлөг	26	тол	120	120	90	100	100	100	150	100	80	130	80	100	100	110	100	110	130	
Төл	Эр хурга	27	тол	50	50	50	40	50	50	55	50	60	50	50	50	55	50	50	40	50	
	Эм хурга	28	тол	50	50	50	40	50	50	55	50	60	50	50	50	55	50	50	40	50	
1.5 Ямаа																					
Ухна	29	тол	140	150	150	150	150	150	120	150	120	120	150	160	100	150	180	120	110	150	
Нас гүйцсэн	Эр ямаа	30	тол	120	130	110	130	100	150	100	130	100	120	150	120	90	120	130	100	90	130
	Эм ямаа	31	тол	90	120	90	100	100	70	80	90	75	85	90	100	70	90	100	80	90	90
Өсвөр	Эр борлон	32	тол	60	60	70	70	70	55	75	70	60	45	60	50	40	60	60	50	50	45
	Эм борлон	33	тол	60	60	60	70	70	55	75	70	60	45	60	50	40	60	60	50	50	45
Төл	Эр ишиг	34	тол	35	30	30	30	30	25	25	40	30	30	30	25	35	35	20	35	25	
	Эм ишиг	35	тол	35	30	30	30	30	25	25	40	30	30	30	25	35	35	20	35	25	

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ
ANNUAL AVERAGE PRICES

2014.10.04

Бараа/Сум	Goods/Sum	Алтай Altai	Баян-Уул Bayan-Uul	Бигэр Biger	Бугат Bugat	Дарив Dariv	Дэлгэр Delger	Жаргалан Jargalan	Тайшир Taishir	Тонхил Tonkhil	Төгрөг Tugrug	Халиун Khaluun	Хөхмөрйт Khukhmorit	Цогт Tsoigt	Цээл Tseel	Чандмань Chandmani	Шарга Sharga	Эрдэнэ Erdene	Есөнбулаг Yesunbulag
Гурил \А.Т-1\, 1кг	Flour, grade 1, kg	960	920	1010	850	1100	780	900	850	930	860	880	1100	950	760	1000	920	1000	1000
Гурил \Орос\, 1кг	Flour, Russian, kg	940	920	980	800	1000	0	0	0	740	700	700	1000	900	1300	1200	900	1000	800
Жигнэмэг,\Янзагатай/ дотоод	Biscuit, domestic	350	300	350	500	350	350	350	350	350	350	350	300	400	300	400	300	350	300
Цагаан будаа,\Сайн чанарын/ 1кг	Rice,/best quality/, kg	2000	2200	2400	2000	2200	2300	2200	2200	2000	2100	2000	2200	2500	2000	2500	2000	2200	2000
Шар будаа,1кг	Millet, kg	2500	2000	2000	2000	2000	2000	2500	1800	2300	2500	1600	2000	2000	1800	2000	2000	2000	1800
Элсэн чихэр,1кг	Sugar, kg	2000	2000	2000	2000	2100	2200	2000	1900	2000	2000	1600	2000	2200	2000	2000	2000	2100	1800
Чихэр, /Барбарис/ 1 кг	Candy, kg	7500	6000	5200	6500	4900	5000	6000	4500	5000	8200	4500	6500	6000	4000	6500	4500	5500	4500
Ногоон цай \ Мөнгөн аягатай\	Green tea, 2 kg	7000	6000	7500	7500	6500	6000	6500	6500	6500	6000	5000	7000	6000	6000	6000	6000	6000	5500
Давс \ иоджуулсан\ 1 кг	Salt, iodated, kg	800	1000	1000	1000	700	800	1000	700	700	650	700	1000	1500	1500	800	1000	1500	600
Ургамлын тос, л/Санни/	Vegetable oil, l	4000	3500	3700	3750	3600	3500	3800	4000	4000	3500	3500	3500	4000	3000	4000	3800	4500	3200
Архи, дотоод, 0.5 л /Ерөөл/	Alcohol, domestic, 0.5 l	7500	7500	7750	7500	6900	8000	7500	7500	7000	8000	7000	7000	7000	7000	7500	7000	7000	6500
Дүнсэн тамхи \Орос\	Making, Russian	6000	6000	8000	7500	6800	5000	8000	7000	8000	6500	7500	6500	7500	7000	7500	6000	7500	5500
Шүдэнз \орос\	Match, Russian	500	500	550	600	500	500	600	500	500	600	500	600	600	500	600	500	500	400
Марль 1м	Gauze, m	1500	1200	1000	1000	1300	700	2000	600	1000	1200	1000	1500	1500	1350	1000	1500	1000	1000
Эдийн саван /ОК/ Угаалгын нунтаг\ОМО\400 гр ууттай	Laundry soap Washing detergent /ОМО/400gr	800	600	700	700	800	600	650	700	650	600	600	700	800	600	600	650	800	500
Цоохор даавуу \Хямд\ 150 см өргөнтэй	Cotton cloth /distress prices/ wide 150sm	3000	3000	2800	2500	3600	4000	2800	3000	2000	3000	4200	3500	3000	3500	3000	3000	3500	2500
Лаа \Хятад\	Candle, China	5500	3800	3300	4000	3800	0	2500	0	2000	4000	2800	3000	3000	4000	1200	3000	3000	1800
Нүүр гарын саван \LUX\	Beauty soap, LUX	400	300	350	400	350	350	500	300	300	300	400	500	350	400	350	400	500	250
Шүдний оо, ш, \PS\ 130 гр том	Tooth-paste, PS, 130g big	900	700	800	500	800	800	800	750	600	700	800	700	800	600	800	800	800	500
Радионы зай \Хятад\, 1ш	Battery, china Cigarette, Ulaan shonkhor	2100	1800	1500	1500	1500	1800	1800	2000	1500	1500	1500	2000	1700	1500	1850	1200	1800	1500
Янжуур \ Улаан шонхор\	Petrol "AI-80" litre	1200	500	800	500	500	500	600	600	800	500	600	500	600	600	600	500	500	300
Бензин, АИ-80, 1л	Cost of travel	1800	1800	1800	1800	1600	2000	1700	1700	1600	1800	1500	1600	1700	1500	1800	1500	1600	1500
Сумаас аймаг орох нэг талын зардал	Electricity, 1kWt.h	1850	1800	1850	1820	1750	1800	1750	1750	1800	1850	1800	1800	1870	1840	1870	1760	1820	1690
Цахилгаан задгай, 1кВт.ц		30000	10000	10000	18000	18000	6000	12000	4000	18000	12000	10000	18000	25000	18000	20000	7000	20000	0
		120	96	93	120	105.6	150	105.6	88	88	100	90	99	100	120	96.5	79.8	100	79.8

**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН сумаар,оны үнээр GROSS
INDUSTRIAL OUTPUT, by som, at current price**

мян.төг / thous.tug/

Сумд	Som	2013.IX	2014.IX	Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2013	2014
Нийт дүн	Total	9430336.9	6997965.1	100.00	100.00
Алтай	Altai	30921.0	37104.3	0.33	0.53
Баян-Уул	Bayan-Uul	8863.7	9368.9	0.09	0.13
Бигэр	Biger	29655.4	53332.2	0.31	0.76
Бугат	Bugat	32903.2	31330.8	0.35	0.45
Дарив	Darib	121436.3	141663.9	1.29	2.02
Дэлгэр	Delger	35340.8	59328.3	0.37	0.85
Жаргалан	Jargalan	5192.2	13901.0	0.06	0.20
Тайшир	Taishir	63092.1	159903.4	0.67	2.28
Тонхил	Tonhil	17372.0	14766.4	0.18	0.21
Төгрөг	Tugrug	12480.3	11145.4	0.13	0.16
Халиун	Haliun	6061.3	11162.1	0.06	0.16
Хөхморьт	Huhmorit	19202.2	22944.6	0.20	0.33
Цогт	Tsogt	14323.9	47559.8	0.15	0.68
Цээл	Tseel	24763.8	48413.6	0.26	0.69
Чандмань	Chandmani	77209.3	98223.5	0.82	1.40
Шарга	Sharga	11250.8	14331.9	0.12	0.20
Эрдэнэ	Erdene	72499.1	66082.5	0.77	0.94
Есөнбулаг	Yesunbulag	8847769.4	6157402.5	93.82	87.99

**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ сумаар,оны
үнээр GROSS INDUSTRIAL OUTPUT, by som, at current price**

мян.төг / thous.tug/

Сумд	Som	2013.IX	2014.IX	Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2013	2014
Нийт дүн	Total	6020598.0	6499873.7	100.00	100.00
Алтай	Altai	16879.6	18592.6	0.28	0.29
Баян-Уул	Bayan-Uul	25982.9	25175.4	0.43	0.39
Бигэр	Biger	63047.9	99233.4	1.05	1.53
Бугат	Biger	18882.1	19232.7	0.31	0.30
Дарив	Darib	132423.8	169438.4	2.20	2.61
Дэлгэр	Delger	50427.4	90202.2	0.84	1.39
Жаргалан	Jargalan	16492.5	20948.8	0.27	0.32
Тайшир	Taishir	69834.5	177209.9	1.16	2.73
Тонхил	Tonhil	19596.5	17600.8	0.33	0.27
Төгрөг	Tugrug	18664.3	15441.0	0.31	0.24
Халиун	Haliun	12500.7	18951.1	0.21	0.29
Хөхморьт	Huhmorit	15945.3	27767.2	0.26	0.43
Цогт	Tsogt	29304.2	37149.5	0.49	0.57
Цээл	Tseel	16758.2	18642.7	0.28	0.29
Чандмань	Chandmana	99836.0	120692.8	1.66	1.86
Шарга	Sharga	16602.0	16061.7	0.28	0.25
Эрдэнэ	Erdene	78877.9	86525.1	1.31	1.33
Есөнбулаг	Yesunbulag	5318542.3	5521008.6	88.3	84.9

ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ
PRODUCTION OF MAJOR COMMODITIES

Бүтээгдэхүүн	Commodities	Хэмжих нэгж	Unit	2013.IX	2013.I-IX	2014.IX	2014.I-IX	2013.I- YI 2014-I- YI
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж			Electricity, thermal energy and water supply					
Цахилгаан эрчим хүч	Electricity	мян.квт.цаг	thous.kW.h	2610.7	22474.8	1657.6	14329.1	63.8
Дулааны эрчим хүч	Thermal energy	мян. Гкал	thous.Gkal	0.0	90.7	0.0	92.4	101.9
Түгээсэн цэвэр ус	Distribution of water	мян. м3	thous.m3	10.5	109.0	10.3	110.6	101.5
Сувагжуулалт	Water carriage	мян.м3	thous.m3	3.7	55.2	5.4	60.5	109.6
Уул уурхай, олборлох аж үйлдвэр			Mining and guarring					
Нүүрс	Coal	мян.тн	thous.Gkal	2.2	15.1	1.3	17.8	117.9
Алт		тн		0	0.0	0.021	0.093	0.0
Боловсруулах аж үйлдвэр			Manufacturing					
Гутал, ботинк	Leather boots, shoes	хос	pairs	52	676	229.0	467.0	69.1
Монгол дээл	National costume /deel/	ширхэг	pcs	127	945	133.0	790.0	83.6
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	Kind of sausage	тн	t	1.3	9.16	1.3	8.7	95.0
Архи, дарс	Alcohol, wine	мян.л	thous.l	2.9	27.1	2.4	29.8	110.0
Амтат ус, ундаа, жүүс	Soft drinks, juice	мян.л	thous.l	20.5	24.58	6.1	60.1	244.5
Банш	Dumpling	тн	t	0.0	0.0	0.3	1.4	0.0
Талх, нарийн боов	Bread, bakery products	тн	t	15.36	121.9	25.7	198.3	162.7
Арвайн гурил	Flour made of barley	тн	t	3	3	6	14.6	486.7
Блок	Block	мян.ш	thous.pcs	4.7	8.2	12.6	18.8	229.3
Хуванцар цонх		м2	m2	85	85	187.6	582.6	685.4
Улаан тоосго	Red brick	мян.ш	thous.pcs	408.7	414.4	220	954	230.2

АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, оны үнээр
SOLD PRODUCTION OF INDUSTRY, at division, at current prices

Салбар	Divisions	2013.IX	2014.IX	2013.I-IX	2014.I-IX	мян.төг <i>thous tog</i>	
						Дүнд эзлэх хувь Percentage	
						2013	2014
Бүгд	Total	555021.3	946252.2	6020598.0	6499873.7	100.0	100.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	Mining and quarrying	77385.0	65660.0	461219.8	635695.4	7.7	9.8
Нүүрс олборлолт	<i>Mining of coal and lignite, extractoin of peat</i>	77385.0	65660.0	461219.8	635695.4	7.7	9.8
Боловсруулах аж үйлдвэр	Manufacturing	197406.2	286177.3	1601153.8	1393390.2	26.6	21.4
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	<i>Manufacture of food products and beverages</i>	71004.3	136054.5	447153.4	830682.6	7.4	12.8
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	<i>Milk, dairy products</i>	0	7000.0	0	16000.0	0.0	0.2
Талх, нарийн боов үйлдвэрлэл	<i>Bread, bakery products</i>	31654.3	93674.5	230602.4	445087.2	3.8	6.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	<i>Other manufacture of food products</i>	16700	20850.0	96905	175452.2	1.6	2.7
Ундаа үйлдвэрлэл/согтууруулах ундаа ороод/	<i>Soft drink and alcohol, wine</i>	22650.0	14530.0	119646.0	194143.2	2.0	3.0
Хувцас үйлдвэрлэл	<i>Manufacture of wearing apparel dressing</i>	15608.5	39236.0	73133.5	62687.5	1.2	1.0
Арьс шир боловсруулах, гутал үйлдвэрлэл	<i>Tanning, manufacture of footwear</i>	2590.0	4360.0	28718.0	12622.0	1.2	0.2
Модон эдлэл / тавилга/ үйлдвэрлэл	<i>Manufacture of wood and wooden products</i>	25340.0	6900.0	124727.0	58469.0	0.5	0.9
Барилгын материал үйлдвэрлэл	<i>Manufacture of construction materials products</i>	38743.4	96496.8	472706.9	353610.8	2.1	5.4
Төмөр бетонон эдлэл	<i>Manufacture of ferroconcrete products</i>	29040.0	0.0	322713.0	20000.0	7.9	0.3
Төмөр эдлэл үйлдвэрлэл	<i>Manufacture of basic metals</i>	0.0	980.0	67166.0	7584.1	5.4	0.1
Бусад үйлдвэрлэл	<i>Other products</i>	15080.0	2150.0	64836.0	47734.2	5.4	0.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	Electricity, thermal energy and water supply	280230.1	594414.9	3958224.4	4470788.1	65.7	68.8
Цахилгаан үйлдвэрлэл	<i>Electricity</i>	256237.3	165906.2	1910046.9	1685157.0	31.7	25.9
Дулаан үйлдвэрлэл	<i>Thermal energy</i>	0.0	388823.0	1693124.8	2393000.6	28.1	36.8
Ус ариутгал, усан хангамж	<i>Water supply</i>	23992.8	39685.7	355052.7	392630.5	5.9	61.8

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, оны үнээр
GROSS INDUSTRIAL OUTPUT, at division, at current prices

мян.төг *thous tog*

Салбар	Divisions	2013.IX	2014.IX	2013.I-IX	2014.I-IX	Дүнд эзлэх хувь Percentage	
						2013	2014
Бүгд	Total	905709.9	879293.6	9430336.9	6997965.1	100.0	100.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	Mining and quarrying	68640.0	40821.9	414841.3	551581.2	4.4	7.9
Нүүрс олборлолт	<i>Mining of coal and lignite, extractoin of peat</i>	68640.0	40821.9	414841.3	551581.2	4.4	7.9
Боловсруулах үйлдвэр	Manufacturing	160402.1	243123.8	1228535.8	1204909.3	13.0	17.2
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	<i>Manufacture of food products and beverages</i>	53496.1	109371.2	388102.0	687600.1	4.1	9.8
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	<i>Milk, dairy products</i>	0.0	5500.0	0.0	10360.0	0.0	0.1
Талх, нарийн боов үйлдвэрлэл	<i>Bread, bakery products</i>	18670.1	77697.2	204582.9	436765.0	2.2	6.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	<i>Other manufacture of food products</i>	19376.0	15870.0	61705.1	99847.3	0.7	1.4
Ундаа үйлдвэрлэл/согтууруулах ундаа ороод/	<i>Soft drink and alcohol, wine</i>	15450.0	10304.0	121814.0	140627.8	1.3	2.0
Хувцас үйлдвэрлэл	<i>Manufacture of wearing apparel dressing</i>	11117.0	30518.2	57290.0	86793.3	0.6	1.2
Арьс шир боловсруулах, гутал үйлдвэрлэл	<i>Tanning, manufacture of footwear</i>	2265.0	7331.0	23469.6	16779.6	0.6	0.2
Модон эдлэл /тавилгал/ үйлдвэрлэл	<i>Manufacture of wood and wooden products</i>	16529.0	6635.0	84970.4	41367.4	0.2	0.6
Барилгын материал үйлдвэрлэл	<i>Manufacture of construction materials products</i>	40275.0	86333.7	262170.8	335320.4	0.9	4.8
Төмөр бетонон эдлэл	<i>Manufacture of ferroconcrete products</i>	25600.0	0.0	310055.0	12200.0	2.8	0.2
Төмөр эдлэл үйлдвэрлэл	<i>Manufacture of basic metals</i>	0.0	510.0	52570.5	4312.0	3.3	0.1
Бусад үйлдвэрлэл	<i>Other products</i>	11120.0	2424.7	49907.5	20536.5	3.3	0.3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	Electricity, thermal energy and water supply	676667.8	595347.9	7786959.8	5241474.6	82.6	74.9
Цахилгаан үйлдвэрлэл	<i>Electricity</i>	652675.0	133441.5	5345057.0	2405274.3	56.7	34.4
Дулаан үйлдвэрлэл	<i>Thermal energy</i>	0.0	428290.0	2086850.1	2464085.4	22.1	35.2
Ус ариутгал, усан хангамж	<i>Water supply</i>	23992.8	33616.4	355052.7	372114.9	3.8	5.3

**ХӨДӨЛМӨР
LABOUR**

**БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны
эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of
period**

Боловсролын түвшингээр	By educational level	2010.XII	2011.XII	2012.XII	2013.XII	9-сар	
						In September	
						2013	2014
Бүгд	Total	817	821	840	1214	892	1200
Үүнээс: эмэгтэй	of which:female	516	519	540	669	554	693
Дээд боловсролтой	Higher education	235	243	325	259	231	379
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	69	64	50	481	63	155
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	39	36	53	37	34	43
Бүрэн дунд	Upper secondary school	294	299	246	287	441	441
Суурь	Compulsory secondary school	143	140	106	96	80	114
Бага	Primary school	30	32	43	45	36	47
Боловсролгүй	Uneducated persons	7	7	17	9	7	21

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2014 оны 9-р сарын
эцэст
NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of
September 2014**

Сар Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	Үүнээс:насны бүлгээр of which:by age group							
			16-24	Эмэгтэй female	25-34	Эмэгтэй female	35-44	Эмэгтэй female	45-59	Эмэгтэй female
I	1241	699	546	298	347	215	206	122	142	64
II	778	429	293	143	241	158	151	91	93	37
III	926	512	258	122	300	192	210	124	158	74
IV	1072	617	363	204	301	180	245	157	163	76
V	1092	672	315	205	338	206	256	170	183	91
VI	1334	805	366	227	410	254	321	202	237	122
VII	1361	796	327	192	439	270	323	198	272	136
VIII	1371	793	324	186	454	276	334	200	259	131
IX	1200	693	312	181	433	254	252	156	203	102

2014 ОНЫ 9 САРД АЖИЛД ОРСОН

ХҮН

NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the
September months of 2014

Cap Mon th	Бүг д Tot al	Улсын үйлдвэр ийн газарт State enterpris e-	Төрийн төсөвт байгуулла гад Governme nt organizatio n	Компани Company	Хоршоо Cooperativ e	Бусад Other
I	0	0	0	0	0	0
II	3			3		
III	108	1	1	84	5	17
IV	57		22	31	2	1
V	77		3	18		56
VI	160		5	68	2	85
VII	2			2		
VIII	119		1	19		99
IX	110		18	13	12	67

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, боловсролын түвшингээр, 2013

оны 9-р сарын эцэст

NUMBER OF UNEMPLOYED PERSONS, by educational level, at the end of
September 2014

Cap Mon th	Бүг д Tot al	Дээд боловс- ролтой Higher educatio n	Тусгай дунд боловсрол той Specialized secondary educatio n	Мэргэжл ийн анхан шатны Skilled workers	Бүрэн дунд боловсрол той Completed secondary school	Суурь боловсрол той Noncomple ted secondary school	Бага боловс - ролтой Comple ted primary school	Боловсролгүй Uned ucated persons
I	124 1	327	477	47	270	87	34	9
II	778	288	238	19	176	35	16	6
III	926	286	204	38	279	81	26	12
IV	107 2	236	241	39	365	128	46	17
V	109 2	261	186	41	394	139	51	20
VI	133 4	313	192	56	536	155	59	23
VII	136 1	347	160	56	575	136	61	26
VIII	137 1	364	162	57	568	131	62	27
IX	120 0	379	155	43	441	114	47	21

АЖИЛГҮЙЧҮҮД, 2014 оны 9 сард ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ХҮН
NUMBER UNEMPLOYED AND NEWLY REGISTERED PERSONS, in the 9 month of 2014

Сар	Month	Ажилгүйчүүдийн тоо, 9-р сарын эцэст			9-р сард шинээр бүртгүүлсэн ажилгүй хүн		
		Number of unemployed, at the end of 9 months			Number of unemployed newly registered in the 9 months		
		2013	2014	2014% 2013	2013	2014	2014% 2013
I		843	1241	147.2	40	63	157.5
II		843	778	92.3	40	29	72.5
III		790	926	117.2	327	256	78.3
IV		948	1072	113.1	299	203	67.9
V		995	1092	109.7	90	200	222.2
VI		743	1334	179.5	58	437	7.5 дахин
VII		814	1361	167.2	0	391	
VIII		944	1371	145.2	287	260	90.6
IX		892	1200	134.5	154	296	192.2

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМДААР
NUMBER OF UNEMPLOYED, by som

Сум	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2010.XII	2011.XII	2012.XII	2013.XII	9-р сар in September		
						2013	2014	2014% 2013
Алтай	Altai	39	39	10	27	30	16	53.3
Баян-Уул	Bayan-Uul	32	32	22	19	28	27	96.4
Бигэр	Biger	20	20	54	53	84	30	35.7
Бугат	Bugat	42	42	48	22	33	25	75.8
Дарив	Darib	54	54	39	44	9	30	333.3
Дэлгэр	Delger	37	37	43	25	30	30	100.0
Жаргалан	Jargalan	13	13	15	18	11	18	163.6
Тайшир	Taishir	12	12	2	9	6	10	166.7
Тонхил	Tonhil	13	13	26	32	35	18	51.4
Төгрөг	Tugrug	15	15	40	37	49	20	40.8
Халиун	Haliun	15	15	20	21	7	17	242.9
Хөхморьт	Huhmorit	13	13	16	15	5	9	180.0
Цогт	Tsogt	39	39	61	61	32	51	159.4
Цээл	Tseel	31	31	53	12	13	25	192.3
Чандмань	Chandmani	48	48	35	44	7	35	500.0
Шарга	Sharga	8	8	14	19	21	24	114.3
Эрдэнэ	Erdene	14	14	16	39	4	35	875.0
Есөнбулаг	Yesunbulag	551	551	326	271	488	527	108.0
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other				446		253	
ДҮН	TOTAL	996	996	840	1214	892	1200	134.5

Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлт

2014.10.07

Д/Д	Сумын нэр	төрсөн эх		эхийн эндэгдэл		төрсөн хүүхэд		Нялхасын эндэгдэл		1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		Нийт нас баралт		Эмнэлэгт нас баралт		Цочмог халдварт өвчлөл бүгд		Үүнээс:															
																		БЗХӨ						Гепатит		Сүрьеэ		Гахайн хавдар		бусад			
		2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014									2013	2014
1	Алтай	12	2			12	1	0	0			6	9		4	5	8			1	6		2	2	0	1				1	0		
2	Баян-Уул	9	17			9	17	0	2	1		6	11	1	2	9	10			5	3		3		0	2	1			2	3		
3	Бигэр	4	4			4	3	1	0			1	9	1	2	5	8			2	2	1	2	1	1	1				0	3		
4	Бугат	9	5			9	5	2	1		1	7	11	4	7	8	9				7		1	1	0	1		5		1	1		
5	Гуулин	1	1			1	1	0	0			3	3	2	1	3	4			2		1	2		0					0	2		
6	Дарив	17	10			17	10	1	0			3		1		5	3			1	2	2	1	2	0					0	0		
7	Дэлгэр	11	8			11	8	0	0	1		8	4	2	1	5	5						2	1	0	3	1			1	2		
8	Жаргалан	1	1			1	1	0	0	1	1	8	10	1	4	3	12		1		2	1	7	1	0			1		0	2		
9	Тайшир	3	1			3	1	0	0			6	6	1		2	11				1		2		2					2	6		
10	Тонхил	17	20			17	20	0	1			14	10	5	3	7	1			6		1		0						0	1		
11	Төгрөг	9	15			9	15	0	1			6	8	1	3	6	4			5	2	1	1		0		1			0	0		
12	Халиун	4	4			4	4	0	0			9	9	3		3	15			1	1	2	4		1		1			0	8		
13	Хөхморьт	4	4			4	4	1	0			5	7	1	2	4	7			1	1	1	3	2	0		2			0	1		
14	Цогт	15	7			15	6	0	0			7	9	3	1	5	4			3	1	2	1		0					0	2		
15	Цээл	10	8			10	8	1	0			10	7	3	1	9	8			6	4	2			0					1	4		
16	Чандмана	12	5			11	5	1	0			11	8	2	4	5	5				2	1		1	0	2	1			1	2		
17	Шарга		1				1	1	0	2		10	6	2		1	10			1			1		0		5			0	4		
18	Эрдэнэ	8	6			8	6	4	1	1		15	16	6	4	2	5			1	1		1		0					1	3		
19	Баянтоорой	2	3			2	3	0	3			6	7	2	3	3	1			2				1						1	0		
20	Сумын дүн	148	122	0	0	147	119	12	9	6	2	141	150	41	42	90	130	0	1	37	35	15	33	11	5	10	12	6	0	11	44		
21	Есөнбулаг	914	861			926	867	13	18			92	86	28	34	123	273	1		33	56	40	78	2	4	6	15	13		28	120		
22	Дүн	1062	983	0	0	1073	986	25	27	6	2	233	236	69	76	213	403	1	1	70	91	55	111	13	9	16	27	19	0	39	164		

МОНГОЛ БАНКНЫ ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН КАССЫН МЭДЭЭ
 INCOME, EXPENDITURE, LOAN, DEPOSIT OF MONGOL BANK

Үзүүлэлтүүд Indicators		Өмнөх оны мөн үе Previous year	сая.төг	mln.tog	Хувь percentage
			Гүйцэтгэл Performance		
Зузаатгал	Money supply	18453051.0	19205186.0		104.1
Цэвэр орлого	Income	269783017.7	215211160.0		79.8
Бэлтгэлд хийсэн	With draw money	19806461.0	19191718.0		96.9
Цэвэр зарлага	Expenditure	263752379.8	222437690.8		84.3
Зээл	Loans	63472530.8	81768550.3		128.8
Үүнээс:					
Чанаргүй зээл	Non-performing loans	108032.6	226146.6		2 дахин
Хадгаламж	Deposit	35998034.7	38313591.5		106.4
Үүнээс:					
Хугацаат хадгаламж	Term deposit account	25832854.5	24800079.9		96.0